


БАТЛАВ:  
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ - ХАЛХЫН  
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
...../Б.САРАНТУЯА/



БАТЛАВ:  
“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
...../Ц.ЭНХТҮВШИН/



## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2021 оны 05 сарын 19 -ны өдөр

Дугаар-5

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

мөст 6/16

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын гаргасан 2021 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн 67 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2021 оны 05-р сарын 13-ны өдрийн 11/07 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Газар зүйн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн О.Батхүү, Ус ашиглагчийг төлөөлж Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1 дүгээр баг, 3212010001 улсын бүртгэлийн дугаартай, 2004879 регистрийн дугаартай “Шивээ-Овоо” ХК-ийн ерөнхий инженер Г.Гэрэлхүү нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: MV-000901А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Шивээ-Овоогийн” нүүрсний ордоос ил аргаар хүрэн нүүрс олборлоход газрын доорх усыг шавхан зайлуулан биологийн нөхөн сэргээлт, зам талбайн тоосжилт дарах болон унд ахуйн хэрэгцээнд ашиглана.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: **4'330'555.0** м<sup>3</sup>/жил

2.2.1 Унд ахуйд: **30'555.0** м<sup>3</sup>/жил

2.2.2. Уурхайгаас шавхан зайлуулахад: **4,300,000.0** м<sup>3</sup>/жил, Үүнээс:

2.2.3 Биологийн нөхөн сэргээлтэнд: **15,480.0** м<sup>3</sup>/жил

2.2.4 Зам талбайн тоосжилт дарахад: **90,432.0** м<sup>3</sup>/жил

нийт **72'240.00** м<sup>3</sup>/ жил усыг эргүүлэн ашиглана.

2.3. Усны чанар, найрлага: Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилт шинжилгээний лабораториор шинжлүүлж, улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS:0900-2018 улсын стандартыг

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Ажилчдын ундны усанд зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулсан. Худаг тус бүрт LXLG-80 маркийн тоолууртай, ЭЦВ6-10-140, ЭЦВ8-25-150, НВ-10, SP46-22, SP30-20, SP48-18 маркийн насосаудаар тоногдсон.

2.5. Хаягдал ус: Унд ахуйн бохир усыг ёмкосонд хуримтлуулж бохирын машинаар хөрсөнд нэвчүүлдэг. Уурхайн шавхан зайлуулсан шүүрлийн усны 30 хувийг цэнгэгжүүлэх төхөөрөмжөөр дамжуулж төмөр болон бусад хүнд металаас ангижруулж уурхайгаас баруун тийш төмөр замын цаана 2,1 км-т Хаялагын нууранд жилийн турш тасралтгүй хаядаг.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Ашигт малтмалын газрын уул уурхайн шинжилгээ туршилтын лабораторт Хаялгын нуурын усанд шинжилгээ хийлгэсэн.

Жинлэгдэх бодис, кг:.....

Органик бодис, кг:.....

Эрдэс бодис, кг:.....

Хүнд металл, кг:.....

Аюултай бохирдуулах бодис, гр:.....

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна. Уурхайн ус шүүрүүлэхийн худгуудаас шавхсан усыг төмөргүйжүүлэх байгууламж буюу усыг цэнгэгжүүлэх төхөөрөмжөөр дамжуулж төмөр болон бусад хүнд металаас нь ангижруулан төв коллектор шугамаар дамжуулан Хаялагын нууранд цутгадаг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу уурхайн ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх **30'555.0** м<sup>3</sup> усыг төлбөрөөс чөлөөлнө.

Уурхайн ухлагаас шавхан зайлуулж буй усны төлбөр:

1м<sup>3</sup> газрын доорх усны үнэ **3,700төг/м<sup>3</sup> x 0,15 x 0,3 = 166.5 төг/м<sup>3</sup>**

3,700төг/м<sup>3</sup> Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

0,15 (15%)-326-р тогтоолын 7(в) усыг шавхан зайлуулах усны хувь хэмжээ.

0,3- Дотоодын хэрэгцээнд нийлүүлж буй нүүрсний олборлолтын шавхан зайлуулах зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох итгэлцүүр

**4,300,000.0м<sup>3</sup> x 166.5 төг/м<sup>3</sup> = 715,950,000.0 төгрөг**

Уурхайгаас шавхан зайлуулах: **4,300,000** м<sup>3</sup>/жил усыг газрын доорх усны төлбөрөөр тооцож **715,950,000.0** /долоон зуун арван таван сая есэн зуун тавин мянган/ төгрөгийг Говьсүмбэр аймгийн төрийн сан банкны **220000944** тоот дансанд төвлөрүүлнэ.

**Жич:** Уурхайн ухлагаас шавхан зайлуулж буй газрын доорх усны төлбөрийг ус зайлуулах төв шугаманд тохирсон баталгаат тоолуур суурилуулж тухайн тоолуурын заалтаар төлбөрийг тооцно. Тоолуур суурилуулаагүй тохиолдолд "Усны газар"-ын гаргасан ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн төлбөрийг тооцох болно.

Төлбөрийн 75%-ийг эхний 3 улиралд үлдсэн 25%-г төгрөгийг 12-р сарын 15-ны дотор барагдуулж дуусгана.

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээ, ус ашиглалтын тайланг 2021 оны 12-р сарын 15-ны дотор ирүүлнэ.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь Усны тухай хуулийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх.

3.2.2. Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.3. Шавхан зайлуулах шүүрлийн усны шинжилгээг хагас жилд нэг удаа хийлгэж шинжилгээний дүн хариуг Сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.4. Ажилчдын ундны усны шинжилгээг улиралд нэг удаа хийлгэж шинжилгээний хариуг Сав газрын захиргаанд ирүүлнэ.

3.2.5. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь

3.2.6. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.7. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ шийдвэрлэж байх.

3.2.8. Шавхан зайлуулж буй шүүрлийн усыг зам талбай, ногоон байгууламж, хайгуулын өрөмдлөг, тэсэлгээний ажилд ашиглах.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.


4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:  
Умард говийн гүвээт-Халхын дундад  
талын сав газрын захиргааны Газар зүйн  
систем, усны мэдээллийн дэд сан  
хариуцсан мэргэжилтэн

...../ О.Батхүү/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг,  
Сүмбэр сум, 3-р баг, 12-р байр 46 тоот  
Харилцах утас: 7054-3598  
Факс: 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:  
"Шивээ-Овоо" ХК-ийн Ерөнхий  
инженер

...../Г.Гэрэлхүү/

Хаяг: Говьсүмбэр аймаг  
Шивээговь сум, 1 дүгээр баг

Харилцах утас: 70546464  
Факс: 99031772